Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН АЖЛЫН АЛБАНЫ 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2022 оны 12 дугаар сарын 12 — Улаанбаатар хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1. ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССУУДЫГ БОДЛОГЫН НЭГДСЭН УДИРДЛАГААР ХАНГАХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 1**. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг таниулах, сурталчлах | | | | | | | |
| 1.1 | Арга хэмжээ 1.1. Иргэд, олон нийтэд хууль сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Үйл ажиллагааны болон мэдээлэл, зөвлөгөө авсан иргэдийн тоогоор | 2021 оны жилийн эцсийн байдлаар 1095 хүнд хууль зүйн мэдээлэл өгсөн. | Иргэд, олон нийтэд хууль сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж үйл ажиллагаа болон хуулийн талаарх ойлголт авсан нийт иргэдийн тоо гарсан байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, цагаатгал, нөхөх олговор, хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах талаарх мэдээллийг утсаар болон цахимаар 857 иргэнд хүргэж, биечлэн 722 иргэнийг хүлээн авч уулзсан ба нийтдээ давхардсан тоогоор 1579 иргэнд зөвлөгөө мэдээ лэл өгч ажилласан байна. Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12 Биелэлтийн хувь: | 90% |
| **Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 2.** Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Арга хэмжээ 2.1. Салбар комиссоос иргэд, олон нийтэд хууль сурталчлан таниулах, цагаатгагдсан хэлмэгдэгчдийн нэхэмжлэгчдийг олж тогтоох, тэдэнд нөхөх олговор олгох ажлын явцын үр дүн, тайланг нэгтгэн танилцуулах | - | Салбар комиссуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг улирал тутам авч, дүнг нэгтгэн Улсын комиссын даргад уламжилснаар. | 2021 оны 1,2,3,4 дүгээр улирлын тайланг хүлээн авч Улсын комиссын даргад уламжлан дүгнүүлсэн. | Салбар комиссын гүйцэтгэлийн төлөвлөгөөний улирлын тайланг улирал бүр нэгтгэж Улсын комиссын даргад уламжилж дүгнүүлсэн байна. | - Салбар комиссуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2022 оны 1-4 дүгээр улирлын тайланг тухай бүр хүлээн авч, уншиж танилцан, үнэлж дүгнэж, тэдний ажлын үр дүнгээр урамшуулал олгож ажиллалаа. Урамшуулал олгох тухай Улсын комиссын даргын 4 удаагийн тогтоол батлагдан гарч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Салбар комиссын ажил 95 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдлээ.<br>- Иргэд, олон нийтэд хууль сурталчлан таниулах, цагаатгагдсан хэлмэгдэгчдийн нэхэмжлэгчдийг олж тогтоох, тэдэнд нөхөх олговор олгох ажлын явцын судалгааг Салбар комисс тус бүрээр гарган нэгтгэж, удирдлагуудад танилцуулав.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | 90% |
| 2.2 | Арга хэмжээ 2.2. МУДШ, МУЕПГ, ТЕГ зэрэг хамтран ажилладаг байгууллагаас ажлын тайлан, мэдээг авч нэгтгэн ҮАБЗ болон Улсын комиссын даргад танилцуулж, өгөгдсөн чиглэлийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах | - | Хамтран ажилладаг байгууллагаас ажлын тайлан, мэдээг авч нэгтгэсэн байдлаар болон ҮАБЗ болон Улсын комиссын даргад танилцуулж, өгөгдсөн чиглэлийн | 2021 оны байдлаар МУДШ-ээс 21, МУЕПГ-аас 13 нийт 34 иргэнийг цагаатгасан тухай тайлан мэдээг авсан. | МУДШ, МУЕПГ, ТЕГ зэрэг хамтран ажилладаг байгууллагаас ажлын тайлан, мэдээг авч нэгтгэн ҮАБЗ болон Улсын комиссын даргад танилцуулсан байна. Энэ дагуу өгөгдсөн чиглэлийн хүрээнд арга хэмжээ зохион байгуулах ажлыг 2023 оны гүйцэтгэлийн | - УПЕГ нь 2022 онд урьд оны мөрдөн байцаалтын үлдэгдэл 37, шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэрэг үүсгэсэн 149, шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэрэг үүсгэсэн хэргээс тусгаарласан 3, 1998 оноос хойш шинээр илэрсэн нөхцөл байдлаар хэрэг үүсгэн шалгаад улс төрийн хилс хэрэгт холбогдсон гэх нотлох баримт тогдоогдоогүйгээс мөрдөн байцаалтыг зогсоосон болон төв, орон нутгийн архивуудаас 2017-2019 онд | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүрээнд арга хэмжээ зохион байгуулж ажилласан байдлаар | | төлөвлөгөөнд тусгасан байна. | татан төвлөрүүлснээс сэргээсэн 87 хэрэг, эдгээр хэргээс тусгаарласан 1, нийт 486 хүнд холбогдох 277 хэргийг шалгах ажиллагаанд хяналт тавьж ажилласнаас 409 хүнд холбогдох 222 хэргийг хянаж, прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгон шийдвэрлэснээс 22 хэргийн 115 хүнийг улстөрийн шалтгаанаар хилсээр мөрдөгдөж, шалгагдсан болохыг тогтоож, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.5 дугаар зүйл, Улстөрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу прокурорын тогтоолоор улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэнд тооцож шийдвэрлэв. Одоо мөрдөн байцаалтад 27 хэрэг шалгагдаж байгаа ба прокурорын хяналтанд 5 хэрэг байна.<br>- ТЕГ-ын Мөрдөн шалгах газар: Тайлангийн хугацаанд 438 хүнд холбогдох 240 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж шийдвэрлэсэн. Үүнээс: Тусгай архивын 230 хүнд холбогдох 97 эрүүгийн хэрэг, Орон нутгийн архивын 50 хүнд холбогдох 46 эрүүгийн хэрэг, Зогсооснoос сэргээсэн 158 хүнд холбогдох 97 хэрэгт тус тус мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шийдвэрлэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Шийдвэрлэсэн хэргээс: Гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 44 хүнд холбогдох 18 хэргийг шүүхэд шилжүүлэх, гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 103 хүнд холбогдох 18 хэргийг прокурорын шатанд хэлмэгдсэнд тооцон, цагаатгах саналтай шийдвэрлэсэн.<br>- МУДШ нь УЕПГ-аас прокурорын дүгнэлт бичиж ирүүлсэн 25 хэлмэгдэгчид холбогдох 24 хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгасан байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 2.3 | Арга хэмжээ 2.3. ТЕГ-ын Тусгай архивт хадгалагдаж буй шалгагдаагүй хэргийг шалгах, хэрэг нь олдохгүй байгаа, таслан шийтгэсэн тогтоол байхгүй зэрэг асуудлаар ажлын хэсэг гарган орон нутаг болон төвийн томоохон байгууллагын архивт ажиллах. /АЕГ, ЦЕГ, БХЯ зэрэг газруудын архив/ | Улсын төсөв | Хэрэг материал нь олдохгүй байгаа, таслан шийтгэсэн тогтоол байхгүй зэрэг асуудлаар ажлын хэсэг гарган зарим аймаг болон байгууллагын архивт ажиллаж хэрэг, материал татан төвлөрүүлсэн тоогоор | 2021 онд ҮАБЗ-ийн зөвлөмжийн дагуу Завхан, Хөвсгөл, Орхон аймгуудад ажиллаж нийт 184 хуудас баримт материалыг ТЕГ-ын холбогдох газарт татан төвлөрүүлж нягтлан шалгах ажлыг эхлүүлээд байна. | Зарим аймаг болон байгууллагын архивт ажиллаж холбогдолтой хэрэг, материалыг ТЕГ-ын Мөрдөн шалгах газар, Тусгай архивт татан төвлөрүүлж нягтлан шалгах ажил эхэлсэн байна. | Өмнөх онд орон нутгийн архиваас цуглуулсан баримт материал дээр ТЕГ-ын гэрээт ажилтнууд ажиллаж байгаа бөгөөд нягтлан шалгах ажил дуусаагүй тул 2022 онд орон нутгийн архивт ажиллах ажлын хэсэг шинээр гараагүй байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | 50% |
| 2.4 | Арга хэмжээ 2.4. Орон нутгийн архивуудаас татан төвлөрүүлсэн хэрэг, шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт | - | ТЕГ-ын Тусгай архивт татан төвлөрүүлсэн болон нотлох баримтаар | 126 хүнд холбогдох 114 шийдвэрлэх боломжгүй зогсоосон хэргээс | ТЕГ-ын Тусгай архивт татан төвлөрүүлсэн, хуулийн үндэслэлээр шалгах ажиллагааг зогсоосон болон | ТЕГ-ын мөрдөн шалгах газрын мэдээгээр: Улс төрийн гэмт хэрэгт холбогдсон болох нь нотлогдоогүй үндэслэлээр 85 хүнд холбогдох 69 хэргийг, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон хэргийг шалгахад хамтарч ажиллах | | тогтоогдоогүй үндэслэлээр шалгах мөрдөн байцаалт зогсоосон хэргүүдээс шалгаж шийдвэрлэсэн тоогоор | 96 хүнд холбогдох 86 хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.<br>ТЕГТА болон орон нутгийн архивын 745 хүнд холбогдох 614 хэрэг, мөрдөн шалгах ажиллагааг зогсоосон 309 хүнд холбогдох 259 хэрэг нийт 873 эрүүгийн хэрэг шалгагдаагүй байна. ҮАБЗ-ын зөвлөмжийн хэрэгжилт - 52%. | шинээр илэрсэн нөхцөл байдлаар үүсгэсэн хэрэг шалгагдаж цагаатгагдсан иргэдийн тоо гарч нэгтгэгдсэн байна. | өмнө хянан шийдвэрлэсэн шүүх, прокурорын шийдвэр хүчин төгөлдөр үндэслэлээр 143 хүнд холбогдох 123 хэргийг, улс төрийн гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр 58 хүнд холбогдох 7 хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай прокурорт шилжүүлж, 5 хэргийг нэгтгэсэн.<br>Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36 хувиар өссөн дүнтэй байна. | 90% |
| 2.5 | Арга хэмжээ 2.5. Нэхэмжлэгчдийн нотлох баримт бүрдүүлэхэд зөвлөгөө мэдээллээр хангах, нэхэмжлэгчээс ирүүлсэн нөхөх олговрын материалын бүрдүүлэлтэд зөвлөгөө өгч хяналт тавих, Шүүхийн шийдвэрийн дагуу нөхөх олговор авсан иргэдийн мэдээллийг мэдээлийн санд оруулах | - | Иргэдийн тоо болон нөхөх олговрын материалын бүрдүүлэлтэд зөвлөгөө өгч хяналт тавьж бүртгэсэн болон мэдээллийг оруулсан тоогоор | 2021 онд нийт 31 нэхэмжлэгчийн бүрдүүлбэр материалыг бүртгэсэн байна. | Нэхэмжлэгчдийн нотлох баримт бүрдүүлэхэд зөвлөгөө мэдээллээр хангасан болон нэхэмжлэгчээс ирүүлсэн нөхөх олговрын материалын бүрдүүлэлтэд зөвлөгөө өгч хяналт тавьж бүртгэсэн тоо гаргасан байна. | Цагаатгалийн хуульд тусгагдсан нөхөх олговрын нэхэмжлэл гаргах хугацаа хуулийн дагуу 2020.12.31-ний өдрөөр дуусгавар болсон хэдий ч зарим нөхцөл байдлыг нь хүндэтгэн үзэх шалтгаантай хэлмэгдэгсдийн нөхөх олговрыг нэхэмжлэх эрх бүхий 9 /үүнээс 13.1 дэх заалтын хүрээнд хамаарагдах 1, 13.2 дэх заалтын хүрээнд хамаарагдах 8/, хуулийн дагуу 2018 оноос хойш цагаатгагдсан хэлмэгдэгчдийн нөхөх олговрын нэхэмжлэх эрх бүхий 6 /13.1, 13.2 дэх заалтуудын хүрээнд давхар хамаарагдах/ нийт 15 нэхэмжлэгчийн бүрдүүлбэр материалыг нэгтгэн Улсын комиссын удирдлагын | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөлийн хуралд танилцуулсан байна.<br>2019-2021 онд Шүүхийн шийдвэрээр нөхөх олговор авсан 308 иргэний мэдээллийг мэдээллийн санд нэгтгэн оруулсан байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| **Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт 3.**<br>Аймаг, нийслэлийн салбар комиссыг нэгдсэн удирдлагаар хангах | | | | | | | |
| 3.1 | Арга хэмжээ 3.1. Салбар комиссыг бодлогын нэгдсэн удирдлагаар хангах, салбар комиссын дарга, нарийн бичгийн дарга нарт зориулсан сургалт /танхимын болон цахим/ зохион байгуулах | Улсын төсөв | Аймаг, нийслэл, дүүргийн 31 нэгжийн албан хаагчдыг бүрэн хамруулах | 2021 онд цахим сургалт 1 удаа хийгдсэн. | Сургалт, семинар зохион байгуулагдаж аймаг, нийслэл, дүүргийн 31 нэгж бүрэн хамрагдсан байна. | Салбар комиссын нарийн бичгийн дарга нарт ажил эрчимжүүлэх төлөвлөгөө танилцуулах, зөвлөн туслах уулзалтыг 2022.04-05 сард хэсэгчилсэн байдлаар зохион байгуулж 20 салбар комиссыг хамруулав. Соён гэгээрүүлэх ажлын 2022 оны төлөвлөгөөнд заагдсан ажлуудын явц, биелэлтийг хянан, соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн богино хэмжээний бичлэг, шторкийг илгээн, салбар комисс бүр тус тусын ИТХ-ын пэйж хуудсаар түгээн дэлгэрүүлэх ажлыг удирдан зохион байгуулж байна.<br>Нийслэл болон 9 дүүргийн салбар комиссын нарийн бичгийн дарга, асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн уулзалтыг 2022.09.02-ны өдөр зохион байгуулсан. Салбар комиссыг нэгдсэн удирдлагаар хангаж шаардлагатай тохиолдолд утсаар болон цахим шуудангаар холбогдон мэдээлэл, зөвлөгөө, арга зүйгээр хангаж ажиллаж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 3.2 | Арга хэмжээ 3.2. Сум, орон нутгийн салбар комиссын үйл ажиллагаатай танилцах, зөвлөгөө, мэдээллээр хангах, томилолтоор ажиллах | Улсын төсөв | Зорилтод аймаг болон онцлох зарим сумын салбар комиссын үйл ажиллагаатай танилцах, томилолтоор ажиллах | 2021 онд 5 аймагт томилолтоор ажиллаж 49 хүнд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна. | Зорилтод аймаг болон онцлох сумын салбар комиссын үйл ажиллагаатай танилцаж шаардлагатай зөвлөмжийг өгч ажилласан байна. | Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн хэрэгжилтийн явцтай танилцах, хяналт тавих, Салбар комиссын албан хаагчидтай уулзах, ажил эрчимжүүлэх төлөвлөгөөний талаар заавар зөвлөгөө өгөх, иргэд олон нийттэй уулзах зорилгоор Улсын комиссын дарга С.Одонтуяа, нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр болон Улсын комиссын ажлын албаны албан хаагчид 2022.03.03-06-ны өдрүүдэд /3 хоног/ Дундговь, Төв, Өмнөговь аймагт, нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр болон ажлын албаны албан хаагчид 2022.05.18-21-ний өдрүүдэд /3 хоног/ Сэлэнгэ, Дархан-Уул аймагт, 2022.06.05-11-ний өдрүүдэд /6 хоног/ Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудад, 2022.06.23-29-ны өдрүүдэд Өвөрхангай, Баянхонгор, Завхан, Архангай аймагт, Улсын комиссын дарга С.Одонтуяагийн хамт 2022.07.20-21-ний өдрүүдэд Завхан, Архангай аймагт, нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр болон ажлын албаны албан хаагчид 2022.08.11-16-ны өдрүүдэд Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд аймагт, 2022.09.14-20-ны өдрүүдэд Булган, Орхон, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөвсгөл, Увс аймагт, 2022.10.12-13-ны өдрүүдэд Говьсүмбэр, Дорноговь аймагт, 2022.12.03-ны өдөр Говьсүмбэр аймаг болон тухайн аймгуудын холбогдох газруудад удирдамжийн дагуу нийтдээ 21 аймагт ажиллаж, давхардсан тоогоор 230 албан хаагч, 150 орчим иргэдтэй уулзсан.<br>Салбар комиссыг нэгдсэн удирдлагаар хангаж шаардлагатай тохиолдолд утсаар болон цахим шуудангаар холбогдож мэдээлэл, зөвлөгөө, арга зүйгээр хангаж ажиллаж байна. Нийтдээ 21 аймгийн томилолтын зардалд 7,220,200 төгрөгийг төсөвт тусгагдсаны дагуу зарцуулсан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| **Зорилго 2. УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙН ЭХНЭР /НӨХӨР/ ҮР ХҮҮХЭД, АЧ ЗЭЭ НАРТ НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 4.**<br>Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохион байгуулах | | | | | | | |
| 4.1 | Арга хэмжээ 4.1. Шүүхийн шийдвэрийг үндэслэн хуулийн 13-р зүйлийн 13.1, 13.2 дахь заалтад хамаарах иргэдийн нөхөх олговрын мөнгийг олгох ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Шүүхийн шийдвэрт тусгагдсан мөнгөн дүнг үндэслэн төсөвт суугдсан хэмжээнд нөхөх олговор олгогдсон | 2021 онд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийн нөхөн олговорт нийт 123 хүнд 5,000,000,000 төгрөг олгосон. | Шүүхийн шийдвэрийг үндэслэн хуулийн холбогдох заалтад тусгагдсан хэмжээгээр нийт төсөвт суугдсан нөхөх олговрыг олгож, олгогдсон мөнгөн дүн/хүний тоо гарсан байна. | - 2022 оны батлагдсан төсвийн хүрээнд 13 дугаар зүйлд заасан үндэслэлээр 8 дүүрэг, 21 аймгийн нийт 316 иргэнд 14,824,500,000.0 төгрөг олгосон.<br>/Үүнд: СБД-25, ЧД-14, СХД-22, ХУД-24, БЗД-29, 1сая-1, БГД-27, Багануур-7, 1 сая-1, Налайх-5, Баян-өлгий-14, Архангай-5, Булган-6, Дорноговь-6, Говь-Алтай-2, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нэхэмжлэгч иргэдийн тоогоор | | | Дорнод-36, Дархан-9, Хөвсгөл-8, Хэнтий-19, Сүхбаатар-3, Төв-10, Сэлэнгэ-10, 1сая-1, Увс-4, Өвөрхангай-6, Өмнөговь-6, Орхон-8, Дундговь-2, Завхан-4, Ховд-5, Баянхонгор-2, Говьсүмбэр-1/ Үүнээс: 80 сая төгрөгийн нөхөх олговрыг 55 иргэнд, 40 сая төгрөгийн нөхөх олговрыг 260 иргэнд, 20,5 сая төгрөгийг 1 иргэнд, 1 сая төгрөгийг 4 иргэнд олгосон байна.<br>- Улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, дурсгалыг мөнхжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, баримтат нэвтрүүлэг, видео контент бэлтгэх, хуулийг сурталчлах, олон нийтэд хүргэх ажлуудыг зохион байгуулж нийт 128,295,267 төгрөгийг холбогдох гэрээ, тушаал шийдвэрийн дагуу зарцуулсан байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 4.2 | Арга хэмжээ 4.2. Хуулийн 13-р зүйлийн 13.1 болон 13.2 дахь заалтад хамаарах иргэдэд цагаатгуулах болон нөхөх олговор авахад зөвлөгөө өгөх, материалын бүрдүүлбэрт хяналт тавьж, шаардлага хангагдсан иргэдийн материалыг | Улсын төсөв | Зөвлөгөө авахаар хандсан иргэн бүрийг хамруулж, нэр нь өдөр тутмын сонинд нийтлэгдэх шаардлага хангасан иргэдийн тоогоор | 2021 онд давхардсан тоогоор нийт 29 нэхэмжлэгчийн нэрийг өдөр тутмын сонинд нийтлэсэн байна. | Зөвлөгөө авахаар хандсан иргэн бүрийг хамруулж нэгдсэн тоо мэдээ гаргаж, шаардлага хангасан иргэдийн тоогоор нэрсийг сонинд зарласан байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 1579 иргэнд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн цагаатгал, нөхөх олговор, хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах талаарх мэдээллийг танилцуулан шаардлагатай зөвлөгөөг хүргэж Цагаатгалийн хуульд | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Ажлын албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, нэрсийг өдөр тутмын сонинд нийтлэх | | | | | тусгагдсан нөхөх олговрын нэхэмжлэл гаргах хугацаа хуулийн дагуу 2020.12.31-ний өдрөөр дуусгавар болсон хэдий ч хүндэтгэн үзэх шалтгаантай хэлмэгдэгсдийн нөхөх олговрыг нэхэмжлэх эрх бүхий нийт 15 нэхэмжлэгчийн бүрдүүлбэр материалыг нэгтгэн Улсын комиссын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан бөгөөд эдгээр нэхэмжлэгчдээс хүндэтгэн үзэх шалтгаантай 8, хуулийн үйлчлэлийн хугацаанд хамаарах 5 /2018 оноос хойш цагаатгагдсан хэлмэгдэгчдийн нэхэмжлэгч/ нийт 13 нэхэмжлэгчийн нэрийг зохих журмын дагуу өдөр тутмын сонинд нийтэлсэн байна. - ИХШХШТХ-ийн 29 дүгээр зүйлийн 29.3 дэх хэсэгт заасны дагуу Нөхөх олговор, мэдээлэл зөвлөгөө хариуцсан мэргэжилтэн Ж.Ганзориг бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээдээр 19 удаа томилогдон энэ оны 20, өмнөх оны үлдэгдэл болон хойшилж шийдвэрлэгдээгүй байсан 15, нийт 35 шүүх хуралд сууж тайлбар хийсэн байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 4.3 | Арга хэмжээ 4.3. 2021 онд улс төрийн хилс хэргээс цагаатгагдсан 39 иргэний мэдээллийг МУДШ, МУЕПГ, ИХАШШ-ээс татан | Улсын төсөв | Цагаатгагдсан 39 хэлмэгдэгчийн мэдээллийг татан авч Хэлмэгдэгсдийн | 2020 онд цагаатгагдсан 43 хэлмэгдэгчийн мэдээллийг Хэлмэгдэгсдийн мэдээллийн | Цагаатгагдсан 39 хэлмэгдэгчийн мэдээллийг харьяалах салбар комиссуудад мэдэгдэж, | 2021 онд улс төрийн хилс хэргээс Монгол Улсын Дээд шүүхээс цагаатгагдсан 13, Монгол Улсын Ерөнхий прокурорын газраас цагаатгагдсан 26, Анхан шатны | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | авч нэгтгэх, өдөр тутмын сониноор нийтэд мэдээлэх, нэхэмжлэгчдийг олж тогтоох, нөхөн олговрыг олгуулах ажлыг Салбар комиссуудтай хамтарч зохион байгуулах | | мэдээллийн нэгдсэн санд оруулах, нийтэд мэдээлэх, нэхэмжлэгчдийг олж тогтоосон байдлаар | нэгдсэн санд оруулан нийтэд мэдээлж, харьяалах салбар комиссуудад хэлмэгдэгчдийн нэрсийг хүргүүлсэн. | нэхэмжлэгчдийг олж тогтоох, нөхөн олговрыг олгуулах ажлыг Салбар комиссуудтай хамтарч зохион байгуулж эхлүүлсэн байна. | шүүхээс 1 нийт 40 хэлмэгдэгчийн мэдээллийг татан авч Хэлмэгдэгсдийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд нэгтгэн 2022 оны 03-р сард өдөр тутмын сониноор дамжуулан нийтэд мэдээлж, тэдгээр хэлмэгдэгчдийн харъяалах аймаг, нийслэлийн салбар комисст мэдэгдэн нэхэмжлэгчдийг олж тогтоох, нөхөх олговорт хамруулахаар ажиллаж байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| **Зорилго 3. УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙН НЭР ТӨРИЙГ СЭРГЭЭЖ, ДУРСГАЛЫГ МӨНХЖҮҮЛЭХ, ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН ТАЛААР ИРГЭД ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАН СУРТАЛЧЛАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 5.**<br>Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн нэр төрийг сэргээж, дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх асуудлаар олон талт ажил, арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах | | | | | | | |
| 5.1 | Арга хэмжээ 5.1. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх өдрийг 27 дахь удаагаа улс даяар тэмдэглэх ажлыг салбар комисс, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийттэй хамтран тусгай хөтөлбөрийн дагуу хүндэтгэн өнгөрүүлэх | Улсын төсөв | Хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх өдрийг 27 дахь удаагаа тэмдэглэх ажлыг зохион байгуулах газар/оролцсон хүний тоогоор | Нийт 26 удаа хүндэтгэн өнгөрүүлсэн. | Хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх өдрийг 27 дахь удаагаа улс даяар тэмдэглэх ажлыг холбогдох газруудтай хамтран тусгай хөтөлбөрийн дагуу хүндэтгэсэн газар/оролцсон хүний тоо гарсан байна. | "Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын 27 дахь өдөр"-ийг хүндэтгэн өнгөрүүлэх тухай Улсын комиссын даргын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 10 дугаар захирамж, Улсын комиссын нарийн бичгийн даргын А/10 дугаар тушаал гарч, захирамж, тушаалд дурдсан ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Төрийн болон ТББ, хэлмэгдэгчдийн үр хүүхдүүдийн төлөөллийг хамруулан Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргүүдийн нутаг дэвсгэрт байрлах Хэлмэгдэгчдийн дурсгалын хөшөө, цогцолборт хүндэтгэл үзүүлж цэцэг өргөх, МБШТ Гандантэгчэнлин хийдтэй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран Улс орон даяар нэгэн зэрэг буяны ном хуруулах, Хэлмэгдүүлэлтийн талаарх нэвтрүүлэг, ярилцлагыг олон нийтийн хүртээл болгох, автобусны буудлууд дээр постер байрлуулах, үүрэн телефоны оператор компаниар дамжуулан олон нийтэд мессеж хүргэх, фото, график дизайн болон гар зургийн уралдаан зарлах, оюутан, сурагчдад лекц, сургалт зохион байгуулах зэрэг ажил үйлчилгээг аймаг, нийслэл, дүүргүүдийн салбар комисстой хамтран зохион байгуулсан бөгөөд Улсын хэмжээнд зохион байгуулагдсан арга хэмжээнүүдэд 5000 орчим хүн оролцож хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэн өнгөрүүлсэн байна. Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12 Биелэлтийн хувь: | |
| 5.2 | Арга хэмжээ 5.2. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээ болон эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах | - | Шинээр санаачилсан ажил, үйлчилгээ/хүртээл болгосон хүний тоогоор | 2021 онд 3 ном, эмхтгэл бүтээж олон нийтийн хүртээл болгосон байна. | Албан хаагч бүр улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2-оос доошгүй ажил, үйлчилгээ шинээр санаачлан зохион байгуулж олон нийтийн хүртээл болгож, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байна. | - Улсын комиссын ажлын алба, Нийслэлийн салбар комисс хамтран 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр "Хүний эрх ба хэлмэгдүүлэлт" сэдэвт эрдэм шинжилгээний хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт ЦАУЗБУК-ын урилгаар Монгол улсад ажлын айлчлал хийсэн ижил төрлийн мэргэжлийн байгууллага болох БНСУ-ын "Үнэн ба эвлэрлийн хороо"-ны гишүүд, төлөөлөгчид, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | комисс, түүний ажлын алба, Нийслэлийн салбар комисс, Монгол Улсын Дээд Шүүх, Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар, Тагнуулын Ерөнхий газар, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь НҮБ-ын суурин төлөөлөгчийн газар, Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн харьяа Стратеги судлалын хүрээлэн, МУИС-ын Шинжлэх Ухааны Сургууль, Нийгмийн ухааны сургуулийн төлөөллүүд болон бусад эрдэмтэн, судлаачдын нийт 11 байгууллагын 40 гаруй хүн оролцлоо. Хэлэлцүүлгийн зорилго нь:<br>Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсад өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлтийн түүхэн үйл явц, хэлмэгдүүлэлтийн хор уршиг бусад үр дагаврыг арилгахтай холбоотой хууль эрх зүйн орчин, цагаатгалын байгууллагуудын өнөө үеийн хандлага, түүх соёлын нөлөөллийн сайн туршлагыг солилцох, хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сайжруулах, бэхжүүлэх явдал байлаа.<br>Хэлэлцүүлэгт УИХ-ын дэд дарга, Улсын комиссын дарга С.Одонтуяа, Нийслэлийн ИТХ-ын дарга бөгөөд Нийслэлийн салбар комиссын дарга Ж.Батбаясгалан нар мэндчилгээ дэвшүүлж, үг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлсэн ба Улсын комиссын Нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр, Шинжлэх ухааны академийн Олон улсын харилцааны хүрээлэн, Төрийн соёрхолт, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор О.Батсайхан, Хүний Эрхийн Үндэсний Комиссын гишүүн Хууль зүйн Шинжлэх ухааны доктор Б.Энхболд, ҮБЭХорооны Байнгын Хорооны Тэргүүлэх Гишүүн Ли Жэ Сун нар илтгэл тавьж хэлэлцүүллээ.<br>Хэлэлцүүлгийн илтгэл, танилцуулга бүхий нийт 74 хуудас Монгол, Англи хэл дээрх "Хүний эрх ба хэлмэгдүүлэлт" товхимлыг бэлтгэн хэвлүүллээ.<br>- Хэлмэгдэгчдийн нэр төрийг сэргээж, дурсгалыг мөнхжүүлэх, хэлмэгдүүлэлтийн хор уршгийг хүүхэд, залуучуудад танин мэдүүлэх зорилгоор 2022 оны 09 дүгээр сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд "Хүний эрх: хэлмэгдүүлэлт ба цагаатгал" фото график дизайн болон гар зургийн уралдааныг улсын хэмжээнд зохион байгууллаа. Уралдаанд оролцсон нийт 263 гар зураг, 50 график дизайны бүтээлийг хүлээн авч, пэйж хуудсаар олны хүртээл болгон танилцуулсан. Тус уралдааныг нийслэлийн салбар комисс, Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохицуулах салбар зөвлөл, Нийслэлийн Боловсролын газар, Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газартай хамтран зохион байгуулсан ба нийслэл, орон нутгийн авьяалаг хүүхдүүдээс илгээсэн нийт 268 бүтээлээс 1-р байр 1 /2,000,000 төг/, 2-р байр 2 /1,000,000 төг/, 3 байр 3 /500,000 төг/, шагналт байр 4 /250,000 төг/-ийг тус тус шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 5.3 | Арга хэмжээ 5.3. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийн талаар болон соён гэгээрүүлэх асуудлаар нэвтрүүлэг, ном, нийтлэл, өгүүллэг, ярилцлага зэргийг бэлтгэж олон нийтийн хүртээл болгох | Улсын төсөв | Хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийн талаар болон соён гэгээрүүлэх асуудлаар мэдээ, мэдээлэл бэлтгэн мэдээллийн ямар сувгаар хэдэн иргэнд хүргэсэн тоогоор | Хэвлэл мэдээлэл - 5,<br>Ном товхимол -3,<br>Баримтат нэвтрүүлэг -0, эрдэм шинжилгээний хурал-0 тус тус зохион байгуулсан байна. | Хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийн талаар болон соён гэгээрүүлэх асуудлаар ном, мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтийн хүртээл болгосон байна. | Хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах буюу хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр ажил эрчимжүүлэх төлөвлөгөө боловсруулагдан батлагдаж энэ дагуу түүхч, судлаач, иргэд, албан хаагчдаас хэлмэгдүүлэлт болон цагаатгалтай холбоотой яриа, ярилцлагад оролцох хүмүүсийг бүрдүүлэн, олон нийтийн хүртээл болгон ажиллалаа.<br>3 баримтат нэвтрүүлгээр холбогдол бүхий мэдээллийг өгч, 21 аймагт хэлмэгдүүлэлт болон цагаатгалын талаар соён гэгээрүүлэх мэдээллийг хийж, 380 орчим албан хаагч, иргэнийг хамруулаад байна.<br>Байгууллагын цахим сайт, пэйж хөгжүүлэлтийн төлөвлөгөө хуваарийн дагуу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлмэгдүүлэлт, хэлмэгдэгч болон цагаатгалтай холбогдол бүхий 34 мэдээ, мэдээлэл, баримтыг улсын комиссын tsauzbuk.mn веб сайтад байршуулж олон нийтийн хүртээл болгосон.<br>Мөн улсын комиссын пэйж хуудсанд хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийн талаар болон соён гэгээрүүлэх чиглэлээр 536 мэдээ, мэдээлэл, контентийг давхардсан тоогоор нийт 77,971 хүнд хүргэсэн байна. Үүнд: - хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд болон судлаачдын видео контент 33, инфлюсер хүмүүсийн видео 24, постер 28 болон бусад пост мэдээ, мэдээлэл 451 байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 5.4 | Арга хэмжээ 5.4. Батлагдсан төсвийн хүрээнд болон төрийн болон төрийн бус байгууллага, хэлмэгдэгчдийн ар гэрийн хүмүүстэй хамтран аймаг, нийслэл, дүүрэгт хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан хөшөө дурсгалыг шинээр бий болгох, сэргээн засварлах, тохижуулах. /Хамбын-Овоо, ОХУ-д | Улсын төсөв | Батлагдсан төсвийн хүрээнд болон хүсэлт гаргасан төрийн болон ТББ, хэлмэгдэгчдийн ар гэрийн хүмүүстэй хамтран хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан хөшөө дурсгалыг боломжтой тоо/нөхцөлөөр | 2021 онд хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх хөшөө – 0 | Батлагдсан төсвийн хүрээнд болон хүсэлт гаргасан төрийн болон ТББ, хэлмэгдэгчдийн ар гэрийн хүмүүстэй хамтран хэлмэгдэгсдийн дурсгалд зориулсан хөшөө дурсгалыг боломжтой тоо/нөхцөлөөр шинээр бий болгон, сэргээн засварлаж, тохижуулсан байна. | УИХ-ын дэд дарга, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга С.Одонтуяагийн санаачилгаар ЗСБНХУ-д хэлмэгдсэн Монгол иргэдийн гэгээн дурсгалд зориулсан өнөөгийн ОХУ-д байгаа гэрэлт самбар бүхий цогцолборын хуулбар хувийг төрөлх Монгол нутагт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Хэлмэгдэгчдэд зориулсан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэлмэгдэгчдийн дурсгалын самбар гэх мэт/ | | шинээр бий болгох, сэргээн засварлах, тохижуулах | | | ногоон төгөл''-ийн хамт ''Үндэсний цэцэрлэгт хүрээлэн''–д босгохоор Улсын комиссын ажлын алба, Нийслэлийн Салбар комисс хамтран 2022 оны 03 дугаар сараас эхлэн ажилласаар 2022 оны 10 сарын 05-ны өдөр хөшөөг дуусгаж, нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Хөшөөг бүтээхэд төрийн болон төрийн бус олон байгууллагууд дэмжиж оролцсон ба нэлээд ажлыг шат дараатай хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>- Гэрэлт хөшөөний хувилбарын 3D зураг гаргуулах ажлын үнийн саналыг авах ажлыг зохион байгуулж, “3d artist” Т.Пүрэвхүү шалгаран 3D зургийг бэлэн болгосон.<br>- Боржин чулуугаар гэрэлт хөшөөг хийх ажлын үнийн саналыг авах ажлыг зохион байгуулж, “Үүдэн чулуу” ХХК шалгарч, хөшөөг бүтээсэн.<br>- Гэрэлт хөшөөний 6 самбар дээр бичигдэх 249 нэрс бүхий хэлмэгдэгчдийн мэдээллийг ''Хэлмэгдэгчдийн мэдээллийн сан''-аас хайлт хийн бүрдүүлсэн.<br>- 249 хэлмэгдэгчдийн нэрсийг бичих нерж хавтан судалж, холбогдох газруудаас үнийн санал авч ''Уран цайдам ХХК'' шалгарч гүйцэтгэсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Дурсгалын гэрэлт самбарын орчинд тохижилтын ажил хийх, ногоон төгөл байгуулах, улмаар түүнийг 21 аймагт бий болгож буй "Хэлмэгдэгчдийн дурсгалд зориулсан ногоон төгөл"-тэй уялдуулан зохион байгуулахаар "Сүхэспартнерс" ХХК өөрсдийн санаачилга, хүч хөрөнгөөр хөшөөг тойруулан тус бүр 10 метр гурван тал хайлаасан хүрээ татаж, гурван талд нийт 300 ширхэг мод суулгасан. Мөн хөшөөний орчимд нарны эрчим хүчээр ажиллах бөгтөр босоо гэрэл 2 ширхэг, сандал 2 ширхэгийг байрлуулан тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 5.5 | Арга хэмжээ 5.5. Их дээд сургууль, Ерөнхий боловсролын сургуулийн оюутан, сурагчдад Монголд өрнөсөн хэлмэгдүүлэлтийн асуудлаар уулзалт, ярилцлага зохион байгуулах | Улсын төсөв | Соён гэгээрүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээ/оролцсон хүний тоогоор | 2021 онд байдлаар Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж уулзалт, ярилцлага зохион байгуулаагүй. | Ажлын албаны албан хаагч бүр Монголд өрнөсөн хэлмэгдүүлэлтийн асуудлаар 1-ээс доошгүй уулзалт, ярилцлага, хичээл зохион байгуулсан байна. | - 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Хөдөө аж ахуйн их сургуультай хамтран тус сургуулийн багш, оюутнуудад "Монголд гарсан улс төрийн хэлмэгдүүлэлт: дүгнэлт, сургамж" лекц зохион байгууллаа.<br>Лекцийн чиглүүлэгч багшаар Төрийн шагналт, Түүхийн шинжлэх ухааны доктор О.Батсайхан ажилласан бөгөөд ХААИС-ийн 250 орчим багш, оюутнууд хамрагдсан.<br>- "Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын 27 дахь өдөр"-өөр ЕБС-иудын дунд, ахлах ангийн сурагчид, МСҮТ-ийн оюутнууд, төрийн болон төрийн бус | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагын албан хаагчдыг оролцуулсан "Түүхээ эргэн санацгаая" аяныг орон даяар зохион байгууллаа. Хэлмэгдүүлэлт дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийн талаар өсвөр үе, ард иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх зорилготой уг арга хэмжээний хүрээнд "Монголд гарсан улс төрийн хэлмэгдүүлэлт: дүгнэлт сургамж" сэдэвт сургалтыг 2022 оны 09 сарын 02-ны өдрөөс 09 сарын 10-ны өдрийн хооронд орон даяар амжилттай зохион байгуулж, нийслэлийн 9 дүүрэг, орон нутагт 80 сумын ЕБ-ын 176 сургуулийн 18,325 сурагч оюутнууд, 6 төрийн байгууллагын 1,272 албан хаагчид нийтдээ 182 байгууллагын 19,597 хүн хамрагдлаа.<br>- 2022 оны 12 сарын 02-ны өдөр БНСУ-ын ҮБЭХ-ны байнгын хорооны тэргүүлэх гишүүн, Гон Гүг их сургуулийн хууль зүйн тэнхимийн профессор Ли Жэ Сүнийг МУИС-ын Нийгмийн ухааны сургуулийн түүх, хуулийн тэнхимийн оюутнуудтай уулзуулж "Эвлэрэл, энх тайвныг тогтоохын төлөөх Солонгосын хүчин чармайлт" сэдэвт лекц сонсгох ажлыг зохион байгууллаа. МУИС-ын Номын сангийн 303 тоот лекцийн танхимд болсон уг лекцэд нийт 70 оюутан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцож, тавигдсан илтгэлийн сэдвээр сонирхсон асуултаа тавьж ярилцлаа. Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12 Биелэлтийн хувь: | |
| **Зорилго 4. БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ХАНГАХ ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 6.** Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах | | | | | | | |
| 6.1 | Арга хэмжээ 6.1. Байгууллага болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах | - | Байгууллага болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний төлөвлөгөөг тус бүрээр боловсруулан авч батлуулан хэрэгжилтийг хангуулж, тайлагнаснаар | 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 1, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө 9-ийг батлуулан хэрэгжилтийн тайлан мэдээг нэгтгэн гаргасан. | Байгууллага болон албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээний төлөвлөгөөг тус бүрээр боловсруулан батлуулж улирал, хагас жил болон жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг хангуулсан тайланг хүлээн авч дүгнэсэн байна. | Улсын комиссын ажлын албаны болон албан хаагчдын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, түүнтэй холбогдох бусад тогтоол, шийдвэрт заасан шинэчилсэн хэлбэрт нийцүүлэн шинээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Албан хаагчдын улирал, хагас жил, жилийн эцсийн тайланг хүлээн авч дүн шинжилгээ хийн, хангалттай сайн ажилласан албан хаагчдад улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгоод байна. Ажлын албаны хагас жил, жилийн эцсийн ажлын тайланг нэгтгэн гаргаж Улсын комиссын даргад тайлагнаад байна. Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12 Биелэлтийн хувь | 90% |
| 6.2 | Арга хэмжээ 6.2. Байгууллагын шуурхай зөвлөгөөн болон ажлын албаны зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг | - | Байгууллагын шуурхай зөвлөгөөн болон ажлын албаны зөвлөлийн | Байгууллагын хурал – 2 удаа Удирдлагын зөвлөлийн хурал – 4 удаа | Байгууллагын шуурхай зөвлөгөөн болон ажлын албаны зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын | 2022 оны жилийн эцсийн байдлаар: Байгууллагын хурал – 25, Удирдлагын зөвлөлийн хурал – 26 нийт 51 удаагийн хурал зохион байгуулагдсан бөгөөд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | даалгаврын хэрэгжилтийг хангуулж, биелэлтийг сар бүр гаргаж тайлагнах | | хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан, биелэлтийг сар бүр гаргасан байдлаар | | хэрэгжилтийг хангуулж биелэлтийг сар бүр гаргаж тайлагнаж тодорхой үр дүнд хүрсэн байна. | уг хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж удирдлагад танилцуулж ажиллаж байна. Түүнчлэн байгууллагын удирдлагаас өгөгдсөн ажлын цаг баримтлах, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахих, хуулийг сурталчлан таниулах, ажлын тоон тайлан өгөх, хэлмэгдэгчдийн дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинэлэг санаа, санал, санаачилга гаргах, ажлыг гүйцэтгэх, албан томилолтоор ажиллах, салбар комисст мэдээлэл хийх, Улсын комиссын хуралдааны тогтоол үйлдэх зэрэг үүрэг, даалгаврыг цаг тухай бүрт нь хэрэгжүүлж, дотоод журам, дүрмийг мөрдөн ажиллаж байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь | 90% |
| 6.3 | Арга хэмжээ 6.3. Байгууллагын үүсч хөтлөгдсөн баримт бичгийг зааврын дагуу байгууллагын архивт авах, байнгын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлэх, байнга хадгалах баримтыг Үндэсний төв архивт шилжүүлэх, иргэдийн хүсэлтээр зохих лавлагаа мэдээллийг олгох | - | Байгууллагын 2021 онд үүсч хөтлөгдсөн баримт бичгийг заавრын дагуу байгууллагын архивт авсан, байнгын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлсэн, байнга хадгалах баримтыг Үндэсний төв | Байгууллагын архивт-38 хадгаламжийн нэгж<br>Цахимжуулалт-6466 хуудас материал | Байгууллагын 2021 онд үүсч хөтлөгдсөн баримт бичгийг заавრын дагуу байгууллагын архивт хүлээн авч байнгын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, Улсын комисст хадгалагдаж байгаа байнга хадгалах баримтыг Үндэсний төв архивт холбогдох дүрэм, журмын дагуу шилжүүлсэн болон иргэдийн хүсэлтээр зохих лавлагаа | - 2021 онд нийт мэргэжилтнүүдэд үүсч хөтлөгдсөн баримт бичгээр 28 хадгаламжийн нэгж үүсгэсэн. Захирамжлалын баримт бичгүүдийг цахим хэлбэрт шилжүүлэн хадгалж байна.<br>- 2021 онд санхүү, бүртгэл дээр үүсч хөтлөгдсөн албан бичиг, баримтуудыг бэлтгэн 9 нэгж үүсгэсэн<br>- 2021 оны орлого зарлагын - 36 баримт бичгийг 1 нэгж болгон үйлдэв<br>- 2001-2017 оны хооронд үүсч хөтлөгдсөн архивын нийт 1046 нэгж материалыг Үндэсний | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | архивт шилжүүлсэн байдлаар болон иргэдийн хүсэлтийн дагуу зохих лавлагаа мэдээллийг олгосон байдлаар | | мэдээллийг олгосон байна. | төв архивын газар хүлээлгэн өгөв<br>- Устгах акт 423 нэгж,<br>- Үндэсний төв архивын шаардлага хангуулан хүлээлгэн өгөх материал 623<br>- Баримт хүлээлцсэн акт 2<br>- Иргэний өргөдөлтэй холбоотой архивын мэдээлэл шүүх 4 баримт байна.<br>- 2022 оны 1-6 дугаар сарын хооронд салбар комиссуудаар дамжуулан олгосон нөхөх олговрын нийт 266 иргэний санхүүгийн баримт материалыг бүрдүүлэн 10 хадгаламжийн нэгж үүсгэн архивт хадгалав.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 6.4 | Арга хэмжээ 6.4. Албан хаагчдын хүний нөөцийн судалгаанд баяжилт хийх. | Улсын төсөв | Хүний нөөцийн судалгаанд шинэчлэл хийсэн тоогоор | Байгууллагын 11 албан хаагчдын хүний нөөцийн судалгааг ХНУМТ цахим системд шинэчлэл хийх ажил 95 хувьтай биелээд байна. | Албан хаагчдын хүний нөөцийн судалгаанд баяжилт хийгдэж холбогдох хуулийн болон төрийн албан хаагчийн ёс зүй, мэргэжил арга зүйн бүтэн сургалтад хамрагдаж албан хаагчдаас дэвшүүлсэн саналаар болон нийгмийн баталгааны төлөвлөгөөний дагуу асуудлыг хангаж ажилласан байна. | - Жилийн эцсийн байдлаар "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд нийт 14 албан хаагчийн үндсэн болон өмнөх хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийг давхардсан байдлаар 21 удаа засварлан, шинэчлэлт хийсэн. Мөн цалин хөлсний өөрчлөлт, төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох зэрэг холбогдох тушаал, захирамжийн дагуу гарсан өөрчлөлтүүдийг цаг тухайд оруулж, шинэчилж байна.<br>- Албан хаагчдын хувийн хэргийн бүрдэлд шинжилгээ хийн хувийн хэргийн бүрдэл дутуу, шинэчилсэн журмын дагуу бүрдэл үүсгэх | 90% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шаардлагатай албан хаагчдын жагсаалтыг гарган, бүх албан хаагчийн хувийн хэрэгт баяжилт хийгээд байна.<br>- Албан хаагчдын шагналын судалгааг гарган, төрийн одон медалиар шагнагдах болзол хангасан 5 албан хаагч, НИТХ-ын шагналаар шагнагдах 1 албан хаагчийн шагналын анкет, ажил байдлын тодорхойлолтыг бичин, материалыг бүрдүүлж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.<br>- Улсын комиссын шагналаар шагнагдах Салбар комиссын удирдлага, ажилтнуудын судалгааг гарган, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан албан хаагчдыг "Улсын комиссын хүндэт жуух" /10/, "Улсын комиссын хүндэт тэмдэг" /6/-ээр тус тус шагнах захирамжийн төслийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>- Улсын комиссын ажлын албаны 2 албан хаагч Улсын комиссын шагналаар шагнагдав.<br>Тайлант хугацаанд:<br>- Албан хэрэг хөтлөлтийн сургалт 2 удаа, Монгол бичгийн анхан, дунд шатны сургалт 3 удаа, эрүүл мэндийн сургалт 1 удаа зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулсан байна.<br>- Удирдлагын академийн ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтад 1, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 1 албан хаагч тус бүр 3 сарын хугацаанд хамрагдан, амжилттай төгслөө.<br>- Мөн Удирдлагын академийн "Төрийн албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны зохицуулалтын шинэчлэл" богино хугацааны зайн сургалтад 3 албан хаагч, 3 хоног, "Төрийн байгууллага дахь харилцаа, маркетинг" сэдэвт сургалтад 3 албан хаагч, 3 хоног хамрагдан, сургалтаар олж авсан шинэ мэдлэг, мэдээллийг албан хаагчдад хүргэн, холбогдох материалуудыг түгээн ажиллалаа.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| 6.5 | Арга хэмжээ 6.5. Улсын комисст байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хүлээн авч, удирдлагад танилцуулж, хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээг сар тутам гаргаж Улсын комиссын дарга болон Ажлын албаны хуралд танилцуулж ажиллах | - | Улсын комисст байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хүлээн авсан тоо болон хариутай бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн эсэх мэдээг сар тутам гаргаснаар | Төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн албан бичиг – 4769,<br>Иргэдийн өргөдөл, хүсэлт – 1004 /давхардсан тоогоор/<br>Нийт албан бичиг, өргөдөл, хүсэлт – 620<br>Хариутай албан бичиг, өргөдөл, хүсэлт – 179 | Улсын комисст байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, албан бичгийг хүлээн авч, тухай бүр удирдлагад танилцуулан хариутай бичгийг хуулийн хугацаанд шийдвэрлэгдсэн эсэхэд хяналт тавьж, мэдээг сар тутам гарган Улсын комиссын дарга болон Ажлын албаны хуралд танилцуулан, тоон мэдээг гаргасан байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар:<br>- Аймаг, нийслэлийн салбар комисс болон бусад газруудаас 375 албан бичиг /үүнээс хариутай албан бичиг-107/, хувь хүмүүсээс шийдвэрлүүлэхээр ирүүлсэн 145 өргөдлийг хүлээн авч, бүртгэлд тусган удирдлагад танилцуулж, ажилтнуудад хуваарилж, хариутай албан бичгийн мэдээг жилийн эцсийн байдлаар гарган ажиллаж байна.<br>Улсын комиссоос салбар комиссууд болон бусад байгууллага, иргэнд 285 албан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичгийг шуудангаар болон биеэр хүргэсэн байна.<br>- Архив, албан хэрэг хөтлөлтийг цахимжуулах зорилгоор бусад байгууллагуудаас ирүүлсэн 6,088 хуудас албан бичиг, байгууллагууд руу явуулсан 626 хуудас албан бичиг, иргэдээс ирүүлсэн 738 хуудас өргөдлийг скайнердаж, нийт 7,452 хуудас баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлсэн.<br>- Байгууллагын хэмжээнд жилийн эцсийн байдлаар Захирамж-14, А тушаал-21, Б тушаал-36, Тогтоол-9 гарсныг цахим хэлбэрт шилжүүлсэн.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| **Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 7.**<br>Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, систем хөгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах | | | | | | | |
| 7.1 | Арга хэмжээ 7.1. Цахим хуудсыг тогтмол баяжуулах, мэдээллийн ил тод байдлыг хангах | - | Байгууллагын цахим хуудсанд тогтмол баяжилт хийгдсэнээр болон мэдээллийн ил тод байдлыг хангасан байдлаар | 2021 онд цахим хуудсыг бүрэн шинэчлэн 6 ном, эмхтгэл, 10 видео бичлэг, танилцуулга 10, хууль тогтоомж 10, шинэ мэдээ мэдээллүүдийг тухай бүр тус тус оруулж шинэчлэн ажилласан байна. | Цахим хуудсанд тогтмол баяжилт хийгдэж мэдээллийн ил тод байдал хангагдсан байна. | Мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Tsauzbuk.mn цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааны үндсэн 3 чиглэлийн хүрээнд мэдээ мэдээлэл, захирамж, тушаал, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, хүний нөөц, тайлан, шилэн данс зэрэг цэсүүдэд тухай бүр баяжуулалт хийн шинэчилж иргэд, олон нийтэд хүргэж байна.<br>Байгууллагын tsauzbuk.mn цахим хуудсанд ярилцлага видео бичлэг 3, хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болон судлаачдын видео 33, инфлюсер хүмүүсийн яриа видео 24, шинэ мэдээ мэдээлэл 436 тус тус байршуулж шинэчилж ажилласан байна.<br>Улс төрийн хилс хэргээр хэлмэгдэж цагаатгагдсан 31,460 иргэдийн мэдээллийг хөрвүүлэн боловсруулж цахим хуудсанд байршуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12 Биелэлтийн хувь: | |
| 7.2 | Арга хэмжээ 7.2. Мэдээллийн нэгдсэн сангийн програм болон архивын програм хангамжийн аюулгүй байдал, ашиглалт, нууцлал, хадгалалттай холбоотой шинэчлэл хийж, сайжруулж өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах | Улсын төсөв | Холбогдолтой шинэчлэлийг хийгдсэнээр болон өдөр тутмын үйл ажиллагаанд ашигласнаар | шинэ SDD хадгалах диск суурьлуулсан - 8 компьютер,<br>шинээр үйлдлийн систем болон хэрэглээний программ суулгасан - 8 компьютер,<br>Нөөц санах ойд хуулбарласан – 12 удаа,<br>аюулгүй байдал, нууцлал, хадгалалтыг тухай бүр сайжруулж байна. | Мэдээллийн нэгдсэн сангийн програм болон архивын програм хангамжийн аюулгүй байдал, ашиглалт, нууцлал, хадгалалттай холбоотой шинэчлэл үе шаттайгаар хийгдэж өмнөх жилийнхээс ахисан түвшинд сайжруулсан тэдгээрийг өдөр тутмын үйл ажиллагаанд ашигласан байна | Байгууллагын албан хэрэгцээнд сервер дээр ашиглаж байсан хуучин 300MB wifi switch-ийг 1GB boardrouter-ээр, 10/100 16 port-той switch-ийг 10/100/1000 1GB 16 port-той switch-ээр тус тус сольж хэвийн ажиллагаанд оруулсан.<br>Албан хаагчдын нийт 11 компьютерт 1 жилийн хугацаатай ESET антивирусын программ хангамж суурилуулсан.<br>Баяжуулалт хийгдсэн цагаатгагдсан иргэдийн мэдээллийн үндсэн санг сар бүр архивлан 12 файл үүсгэн байгууллагын цахим архивт байршуулан ажиллаж байна.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.3 | Арга хэмжээ 7.3. Улсын комиссоос зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх гэрэл зургийн баримт үйлдэх, цахим архив болгон байгууллагын архивт шилжүүлэх | Улсын төсөв | Үйл ажиллагааны талаарх гэрэл зургийн баримт үйлдсэнээр болон түүнийг цахим архив болгон байгууллагын архивт шилжүүлсэн байдлаар | Үйл ажиллагааны гэрэл зураг – тухай бүр | Улсын комиссоос 2021 онд зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх гэрэл зургийн баримт үйлдэгдсэн түүнийг цахим архив болгон байгууллагын архивт шилжүүлэхэд бэлэн болсон байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл болох цагаатгал, нөхөн олговор, бусад үр дагаврыг арилгах ажлын хүрээнд зохион байгуулсан нийт 35 арга хэмжээний 13,165 гэрэл зураг дарж, 153 минутын 22 видео бичлэг хийгдсэн байна. Үүнд:<br>- 21 аймгийн салбар комиссын үйл ажиллагаатай танилцах, заавар зөвлөгөө өгөх, ажлын хэсгийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор ажилласан албан томилолт<br>- 2022 оны 4, 5 дугаар саруудад 21 аймгийн салбар комиссын нарийн бичгийн дарга нарыг хүлээн авсан албан уулзалт,<br>- Гандантэгчэнлин хийд болон Аглаг бүтээлийн хийдэд хийсэн ярилцлага, уулзалт<br>- 9 дүгээр сарын 10-ны Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр<br>- ЗСБНХУ-д хэлмэгдсэн Монгол иргэдийн гэрэлт хөшөөний нээлт<br>- БНСУ-ын Үнэн ба эвлэрлийн хорооны албан айлчлалын арга хэмжээ зэрэг үйл ажиллагаануудын 13,165 гаруй зургаас сонгон шалгаж, байгууллагын цахим архивт 10,270 гаруй зураг хадгалсан.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.4 | Арга хэмжээ 7.4. Улсын комиссын ажлын албаны номын сангийн баяжилтийг нэмэгдүүлж, хэлмэгдлийн талаарх эрдэмтэн, судлаачдын бүтээлийг олшруулах, хүн амын тооллого, бүртгэлтэй холбогдолтой ном, товхимол худалдан авах | Улсын төсөв | Хэлмэгдлийн талаарх эрдэмтэн, судлаачдын бүтээлийг олшруулснаар болон хүн амын тооллого, бүртгэлтэй холбогдолтой ном, товхимол худалдан авсан байдлаар | "Цөвүүн цагийн улаан зад" /2021 он/<br>"Дилавхутагт Жамсранжавын дуртгал" /2020 он/ зэрэг номнуудыг номын сангийн баяжилт хийж бүргэлжүүлэв. | Улсын комиссын ажлын албаны номын сангийн баяжилтийг нэмэгдүүлж, хэлмэгдлийн талаарх эрдэмтэн, судлаачдын бүтээлийг олшруулсан, хүн амын тооллого, бүртгэлтэй холбогдолтой ном, товхимол худалдан авч номын сангийн бүтээлийн тоог нэмсэн байна. | Номын сангийн бүтээлүүдтэй танилцах хүсэлт гаргасан ажлын албаны албан хаагчид болон 25 иргэнд ном хэвлэлээр үйлчилсэн. Номын сангий карт шинээр 3 иргэнд нээсэн. Номын фондыг "Сүхбаатар аймгийн зарим сүм хийд, лам нарын баримтууд", "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдий намтрын товчоо-18 боть" гэсэн 2 номоор шинээр бүртгэлжүүлэн баяжуулсан.<br>Улсын тооллоготой холбогдуулан байгууллагын номын сангийн тооллого хийж ном тус бүрээр үнэлгээг бүртгэсэн. Нийт 8,725,334 төгрөгийн үнэ бүхий 697 ширхэг ном бүртгэв.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | 85% |
| **Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 8.**<br>Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| 8.1 | Арга хэмжээ 8.1. Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах | Улсын төсөв | Төрийн болон ТББ, хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилласан үйл ажиллагааны тоо, мэдээлэл авсан албан хаагч, иргэдийн тоогоор | Уулзалт зохион байгуулсан төрийн байгууллагын тоо – 4<br>Уулзалт зохион байгуулсан төрийн бус байгууллагын тоо – 2<br>Хэвлэл мэдээллийн байгууллагын тоо – 3 | Төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж зохион байгуулсан арга хэмжээний нэгдсэн үнэлэлт, нийт мэдээлэл авсан албан хаагч, иргэдийн тоо гарсан байна. | 2022 онд Улсын комисс нь Улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, хэлмэгдсэн иргэдийн нэр төрийг сэргээж, дурсгалыг мөнхжүүлэх, соён гэгээрүүлэх ажилд төрийн болон төрийн бус гадаад, дотоодын олон байгууллагатай хамтран ажиллалаа. Үүнд: Хэвлэл мэдээллийн сбайгууллага:<br>- Улстөрч.мн сайт: ЦАУЗБУК-ын Захиргаа, дүн шинжилгээний албаны дарга Л.Очирсүрэнгийн нөхөх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | олговрын тухай 15 минутийн ярилцлага<br>- С1 телевиз: ЦАУЗБУК-ын дарга С.Одонтуяагийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгах, соён гэгээрүүлэх талаарх 4 минутийн ярилцлага<br>- MNB Монголын мэдээ, MNC телевизийн Зочны цаг ярилцлага, Зууны мэдээ сонины polite.mn, Өдрийн сонины dnn.mn цахим сайтуудад Улсын комиссын нарийн бичгийн дарга Г.Төгөлдөрийн ярилцлага<br>- Хөгжил Энтертейнмент студи: хэлмэгдэгсдийн гэр бүлийн талаарх мэдээ контент<br>- “Элгэн нутаг FM” радио болон нийт 13 телевиз, 2 сайт /go go8 NEWS.MN/-аар Улсын комиссоос бэлтгэсэн нэвтрүүлэг, контент, шторкууд үнэгүй цацагдсан.<br>- Үүрэн холбооны Скайтел ХХК, Жимобайл ХХК-ууд “Хэлмэгдчдийн дурсгалын өдөр”-ийн текстийг үнэ төлбөргүйгээр нийт хэрэглэгчдэдээ хүргэсэн<br>- Гандантэгчинлэн хийд: орон нутгийн салбар хийдүүдтэй хамтран хэлмэгдэгчдийн хойдын буянд зориулан орон даяар буяны ном хурах ажил<br>- “Сүхэспартнерс” ХХК: Дурсгалын гэрэлт самбар, хөшөөний тохижилтын ажил, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ногоон төгөл үнэ төлбөргүй бүтээн байгуулсан<br>- "Үндэсний цэцэрлэгт хүрээлэн"<br>- "Хот тохижилтын газар<br>- Бльюспот энимэйшн ХХК: ярилцлага видео бичлэг, хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд болон судлаачдын видео, инфлюсер хүмүүсийн яриа, видео шторк бэлтгэн пэйж хуудсаар олон нийтэд цацагдан хүрч байна. Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| **Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 9.**<br>Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах | | | | | | | |
| 9.1 | Арга хэмжээ 9.1. Улсын комиссын дарга, Нарийн бичгийн дарга нараас гаргасан төсөв, санхүүтэй холбоотой тогтоол, тушаал шийдвэрийн биелэлтийг хангаж холбогдох хууль тогтоомжийн дагуу төсөв хөрөнгийг зарцуулж, тайлан балансыг стандартад нийцүүлэн гаргаж тайлагнах | Улсын төсөв | Биелэлтийг хангаж холбогдох хууль тогтоомжийн дагуу төсөв хөрөнгийг зарцуулсан тухай тоо баримтаар болон тайлан балансыг стандартад нийцүүлэн гаргаж тайлагнасан байдлаар | Тушаал шийдвэрийг биелэлтийг хангаж төсөв хөрөнгийг зарцуулж тайлан балансыг стандартад нийцүүлэн гаргасан<br>Аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авсан.<br>Шилэн дансны мэдээлэл – 204 мэдээлэл оруулсан. | Улсын комиссын дарга, Нарийн бичгийн дарга нараас гаргасан төсөв, санхүүтэй холбоотой тогтоол, тушаал шийдвэрийн биелэлтийг хангаж холбогдох хууль тогтоомжийн дагуу 2021 оны төсөв хөрөнгийг зарцуулсан тайлан балансыг стандартад нийцүүлэн гаргаж тайлагнасан байна. | Улсын комиссын дарга, нарийн бичгийн дарга нараас гаргасан төсөв, санхүүтэй холбоотой тогтоол, тушаал шийдвэрийн дагуу төсөв хөрөнгийг зарцуулж, орлого, зарлагыг сар бүрээр шилэн дансанд байршуулан, НДШ, ХАОАТ-ын сар бүрийн мэдээг төрийн санд цаасаар болон файлаар тайлагнан илгээж байна. Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | 90% |
| 9.2 | Арга хэмжээ 9.2. Байгууллагын эд хөрөнгөд хууль, журамд заасны дагуу тооллого хийх, | Улсын төсөв | 2021 оны тооллого хийснээр болон албан | Ашиглах боломжгүй эд хөрөнгө, техник хэрэгслийг актлах | Байгууллагын эд хөрөнгийн 2022 оны тооллогыг цаг тухай бүрт хийж албан хэрэгцээнд | - 2022 оны эхний хагас жилийн тооллогыг Улсын тооллоготой холбогдуулан Улсын комиссын нарийн бичгийн даргын А/08 тоот тушаалын дагуу эд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | албан хэрэгцээнд шаардлагатай эд материал, техник хэрэгслийг актлах, шинээр авах, картжуулах | | хэрэгцээнд шаардлагатай эд материал, техник хэрэгслийг шинээр авч картжуулсан байдлаар | саналыг холбогдох газар хүргүүлсэн.<br>Албан хэрэгцээнд шаардлагатай хөрөнгийг худалдан авсан. | шаардлагатай эд материал, техник хэрэгслийг шинээр авч картжуулж бүртгэсэн байна. | хариуцагч бүрээр картжуулан, хөрөнгө тус бүрээр зурган хэлбэрт оруулан, burtgel.pscp.gov.mn хаягт заавхрын дагуу бүртгэсэн.<br>- Төрийн өмчийн хорооноос зохион байгуулж буй "Төрийн өмчийн тооллого-2022" улсын тооллогыг байгууллагын үндсэн хөрөнгөд шаардлагын дагуу хийж гүйцэтгэн, төрийн өмчийн хороонд тайлан, дүгнэлт хүргүүлэн, 97,296,054 төгрөгийн /дансны дүнгээр/ эд хөрөнгийн жагсаалтыг тооллогын программд нэгтгэн бүртгэлээ. Тооллогын үеэр ашиглалтын хугацаа дууссан 38,598,350 төгрөгийн эд хөрөнгийн жагсаалт гарган, актлах нэрийн баримт үйлдэв.<br>Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | 90% |
| | | | | | | | |
| **Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт 10.**<br>Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах | | | | | | | |
| 10.1 | Арга хэмжээ 10.1. Улсын комиссоос гарсан эрхзүйн акт холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрт нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийж хяналт тавих | Улсын төсөв | Эрхзүйн акт холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрт нийцсэн эсэхэд тухайн бүр дүн шинжилгээ | Комиссын тогтоол – 4<br>Комиссын даргын захирамж – 8<br>Комиссын нарийн бичгийн даргын тушаал – 37<br>Комиссын албан бичиг – 455<br>Улсын комиссоос гарсан нийт | Улсын комиссоос гарсан эрхзүйн акт холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрт нийцсэн эсэхэд тухай бүр дүн шинжилгээ хийж хяналт тавьсан байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар Улсын комиссоос гарсан тогтоол – 7, захирамж – 13, А тушаал – 20, Б тушаал – 36, албан бичиг – 279 нийт 355 эрхзүйн актад дүн шинжилгээ хийж хяналт тавин ажилласан бөгөөд холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийг ямар нэгэн байдлаар зөрчсөн тохиолдол илрээгүй байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хийгдэж хяналт тавигдсанаар | эрхзүйн актын тоо – 504 | | Эхэлсэн, дууссан огноо: 01.01-12.12<br>Биелэлтийн хувь: | |
| | 2022 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 үндсэн зорилго, /Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 4 зорилт, түүний хүрээнд 14 арга хэмжээ, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 5 зорилт, түүний хүрээнд 13 арга хэмжээ, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 1 зорилт, түүний хүрээнд 2 арга хэмжээ/ нийт 10 зорилтын хүрээнд 29 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн хэрэгжилт 90,3%-ийн гүйцэтгэлтэй байна. | | | | | | |

*Төлөвлөгөөг хянасан:* **Төсвийн Ерөнхийлөн захирагч**

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах
Улсын комиссын дарга ........................ /С.ОДОНТУЯА/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

Тэмдэг 2022.12.15

*(огноо)*

*Төлөвлөгөө тайлагнасан:* **Төсвийн Шууд захирагч**
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах
Улсын комиссын нарийн бичгийн дарга ........................ /Г.ТӨГӨЛДӨР/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

Тэмдэг 2022.12.15

*(огноо)*